



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ХҮРЭЭМАРАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 03 сарын 11 өдөр

Дугаар А/М

Дэлгэрмөрөн

Цэцэрлэгт хүрээлэнгийн доторх тохижилтийн
ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах
тендерийн үнэлгээний хороонд
өөрчлөлт оруулах тухай

Монгол улсын “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дахь хэсгийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх сумын төвийн “Цэцэрлэгт хүрээлэнгийн доторх тохижилтийн ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн үнэлгээний хороо байгуулах тухай 2022 оны А/08 дугаар захирамжид даргаар томилогдсон Ч.Дамдинсандив нь өөр газар ажиллахаар явсан тул үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулсугай.

2. Үнэлгээний хорооны дарга Ч.Дамдинсандив гэснийг сумын Засаг даргын Тамгын газрын Хүнс, жижиг дунд үйлдвэрлэл, хоршооны асуудал хариусан мэргэжилтэн Ч.Бямбадорж гэж өөрчилсүгэй.

3. Тендер шалгаруулалтыг холбогдох хууль, журмын дагуу үр дүнтэй зохион байгуулж, авилга, ашиг сонирхлын зөрчилгүй ажиллахыг Ч.Бямбадоржид үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Санхүүгийн албаны даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Сэрдагва)-д даалгасугай.

ДАРГА



С.СУМЪЯАБАЗАР

D /bichig hereg/ Zahiramj -2022 on

642201007